

Та байшин, орон сууц худалдаж авах эсвэл худалдахдаа яагаад РВG-ийн үйлчилгээг сонгох хэрэгтэй вэ?

Манай шилмэл баг үл хөдлөх хөрөнгийн арвин туршлагатай агентуудаас бүрддэг.

Тус үл хөдлөх хөрөнгийн агенлагын үүсгэн байгуулагч нь хуульч хүн байдаг бөгөөд тэрээр таны гүйлгээг биечлэн хариуцах болно.

Зөвхөн гэрээт төлөвлөгөөгөө биелүүлэхэд гол анхаарлаа хандуулж ажилладаггүй.

Хэлэлцээр хийх мэдрэмж, чадвар:

Манай агентлагын үүсгэн байгуулагч буюу Удирдах Брокер нь үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай хуульч хүн байдаг. Тэрээр өөрийн хэлэлцээр хийх өндөр чадвар, мэдрэмжээ ашиглан таны орон байрыг худалдах эсвэл худалдан авахад хамгийн боломжит үнэ болон нөхцлийг танд олгоно.

Хууль эрх зүйн хамгаалалт:

Та манай Удирдах Брокерын хуульчийн мэргэжил, арвин их туршлагын ачаар хууль эрх зүйн хамгаалалтыг байж болох хамгийн өндөр түвшинд авах болно. Бид хамгийн сүүлийн үеийн илчилгээний хэлбэрийг (байрны мэдэгдэж байгаа бүх гажиг согог, гэмтлийг гаргаж бичсэн бичиг) ашиглах болно. Түүнчлэн, илчилгээг таны хэрэгцээнд нийцүүлэн тохируулах болно.

Өөрийн гэсэн хуулийн зөвлөхөөр гүйлгээнийхээ менежментийг хийлгэх боломж:

Манай агентуудын хэн нь тантай ажиллаж байгаагаас үл хамааран манай Удирдах Брокер таны үл хөдлөх хөрөнгийн гүйлгээнд орсон бичиг баримтуудыг нэг бүрчлэн шалгаж хянах болно. Ингэснээр уг гүйлгээний ээдрээтэй, нарийн ширийн асуудлын талаарх мэдээллийг шууд эх сурвалжаас нь авах боломжтой байна. Бусад компаниудын хийдэг нийтлэг зүйл буюу гүйлгээний менежментийг аливаа лицензгүй туслах ажилтнуудад шилжүүлэх явдлыг бид гаргахгүй.

Бид үл хөдлөх хөрөнгийн зөвлөхүүд болохоос борлуулалтын ажилчид биш.

Борлуулалтын агентуудын дийлэнх нь эхнийхээ жилд л ажлаасаа гарцгаадаг:

Үл хөдлөх хөрөнгийн агентуудын 86 хувь нь ажиллаж эхэлснээсээ хойш нэг жилийн дотор энэ салбарыг орхидог. 93 хувь нь лицензээ шинэчлүүлэх хугацаа нь дуусаагүй байхад энэ салбарт ажиллахаа больсон байдаг. Туршлагагүй агентуудыг авч ажиллуулах нь томоохон корпорац, брокерын компаниудад л ашигтай байдаг. Учир нь тэд олох ашгаа 50 хүртэлх хувиар хувааж авдаг юм. Туршлагагүй агентуудыг олноор нь ажилд авах нь эдгээр олон тооны туршлагагүй борлуулалтын ажилчид ард иргэдэд үйлчилж эхлэх нөхцлийг бүрдүүлдэг.

Бид туршлагатай үл хөдлөх хөрөнгийн агентууд бөгөөд манайд гадны хувьцаа эзэмшигч болон гэрээт төлөвлөгөө гэж байдаггүй:

Бид туршлагатай үл хөдлөх хөрөнгийн агентууд бөгөөд манай компани нь хувийн өмчийн байгууллага болно. Биднийг захирах эсвэл шийдвэр гаргах эрхтэй гадны хувьцаа эзэмшигч гэж байхгүй. Аливаа дарамт шахалт, гэрээт төлөвлөгөө болон борлуулалтын өрсөлдөөнд баригдаж хавчигдалгүй үйл ажиллагаагаа явуулах нь бидний баримталдаг зарчим юм. Томоохон брокерын компаниудын мөрөөдөж л чадах тэр түвшинд танд үйлчилгээгээ хүргэхийн тулд илүү цаг, хүчин чармайлтыг гаргах боломж бидэнд бий.

Та Т. Цэнгэлцэцэгтэй (510) 316-4383 дугаарын утсаар холбогдоно уу.